

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	7
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	7
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн дэлгэрэнгүй тайлан	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5	Зорилтот түвшин	17
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

Мал эмнэлгийн эмийн сорил
БАТАЛГААЖУУЛАЛТЫН УЛСЫН
ЛАБОРАТОРИ УТҮГ-ЫН ДАРГА
Ц.ГАНТӨМӨР ТАНАА

2019 03 25 № 06/593
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус улсын үйлдвэрийн газрын захирал Ц.Гантөмөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, НББОУС-т нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Санхүүгийн тайлан, зорилтот түвшиний гүйцэтгэлийг СТОУС, НББОУС, тэдгээрт аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 01-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ний өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ны аудитын баг хэрэгжүүлэв.

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 39 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

УТҮГ-ын үндсэн зорилгыг Монгол Улсын Мал эмнэлэгийн үйлчилгээг олон улсын болон үндэсний фармакопейн өгүүллийн шаардлага хангасан эм, био бэлдмэлээр найдвартай, тогтвортой хангах, мал эмнэлэгийн эмийн салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон байна.

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын удирдлага төсвийн дараах хууль болон СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан аж ахуй нэгж байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Татвар болон НД-ын багц хуулиуд

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох

стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous 3.0” програм хангамж ашигладаг байна.

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

2018 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь материаллаг байдлын суурийг нийт хөрөнгө, цэвэр хөрөнгө, нийт орлогын дүнгээс тооцоход өндөр байгаа тул нийт зардлын дүнгээс тооцох нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2018 оны Нийт зардал 116.3 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 1.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь материаллаг алдаа илүү давах магадлал бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг Б401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	-	
	Дүн	2	-	

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал илрээгүй.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын удирдлага нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 0.1 сая төгрөгийн зардлын төсөв батлагдсанаас зардлын нийт гүйцэтгэл төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 0.1 сая төгрөг буюу 95.3 хувьтай байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны цахим мэдээллийн системд 18 мэдээлэл оруулахаас 18 мэдээлэл бүрэн оруулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Авлага, өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс тус тус өссөн нь санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заалтыг мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Цалин хөлстэй холбоотой

3.2.1 Илрүүлэлт

Тайлант хугацаанд ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 46.3.2-т "байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулах", Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын хавсралт "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2-т "Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэт арга барилаар ажиллаж өндөр амжилт гаргасан, эсвэл гоц авьяастай ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоно" гэж

заасныг, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, үнэлгээ хуваарилалт, эрх ба үүрэг гэх батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл

Зардлын хэтрэлт үүсэх;

3.2.3 Зөвлөмж

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017.12.31	2018.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	10,776,292.88	1,125,247.39
1.1.2	Дансны авлага	12,139,365.92	12,801,365.92
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	74,054,323.83	73,523,319.73
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	96,969,982.63	87,449,933.04
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	328,167,107.49	888,091,912.10
1.2.2	Биет бус хөрөнгө	27,088,858.27	52,645,687.43
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	355,255,965.76	940,737,599.53
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	452,225,948.39	1,028,187,532.57
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	2,934,000.00	6,649,486.47
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	-	-
2.1.1.4	НДШ–ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,071,800.00	463,400.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-

2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,005,800.00	7,112,886.47
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	4,005,800.00	7,112,886.47
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,206,486,256.88	1,233,840,996.88
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	188,108,836.79	451,141,816.06
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(946,374,945.28)	(663,908,166.84)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	448,220,148.39	1,021,074,646.10
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	452,225,948.39	1,028,187,532.57

4.2 Аудит хийсэн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	398,824,566.29
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг(алдагдал)	-	398,824,566.29
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	35,722.39
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	114,517,329.60
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	1,876,180.64
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	282,466,778.44
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-	282,466,778.44
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	282,466,778.44
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	282,466,778.44
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	94,421,646.39
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	94,421,646.39
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	104,072,691.88
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-	69,286,616.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	16,353,514.60
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	11,224,013.28
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	413,930.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	1,420,000.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	5,374,618.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага		
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(9,651,045.49)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8		-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6			

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	(9,651,045.49)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	10,776,292.88
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,125,247.39

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,206,486,256.88	188,108,836.79	(552,231,699.58)	842,363,394.09
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-		-
3	Залруулсан үлдэгдэл	1,206,486,256.88	188,108,836.79	(552,231,699.58)	842,363,394.09
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	-	-		-
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт		-		-
7	Зарласан ногдол ашиг	-	-		-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-		-	-
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	1,206,486,256.88	188,108,836.79	(946,374,945.28)	448,220,148.39
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл				-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		-	282,466,778.44	309,821,518.44
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	27,354,740.00	-		-
15	Зарласан ногдол ашиг	-	-		-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	263,032,979.27	-	263,032,979.27
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,233,840,996.88	451,141,816.06	(663,908,166.84)	1,021,074,646.10

4.5 Зорилтот түвшин

Үзүүлэлт	2018 оны		Зөрүү	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	тоогоор	хувиар
Нийт орлого	-	-	-	-
Борлуулалтын орлого	94,385,924.00	94,385,924.00	0.00	100.00%
Бусад орлого	-	-	-	-
Хүүгийн орлого	-	-	-	-
Нийт зардал	110,211,016.07	104,072,691.88	- 6,138,324.19	94.43%
ББӨ	-	-	-	-
Цалин	69,286,616.00	69,286,616.00	0.00	100.00%
Нийгмийн даатгалын шимтгэл	8,808,032.60	8,808,032.60	0.00	100.00%
Шуудан холбоо	35,000.00	32,000.00	-3,000.00	91.43%
Цахилгаан	1,984,497.47	0.00	-1,984,497.47	0.00%
Шатахуун	1,430,000.00	1,420,000.00	-10,000.00	99.30%
Бичиг хэрэг	1,230,000.00	1,220,550.00	-9,450.00	99.23%
Хог	-	-	-	-
Хөдөлмөр хамгаалал	-	-	-	-
Ашиглалтын зардал	3,460,430.00	413,930.00	-3,046,500.00	11.96%
Засварын зардал	-	-	-	-
Бусад зардал	20,150,340.00	20,065,463.28	-84,876.72	99.58%
Шагнал урамшуулал	-	-	-	-
Элэгдлийн зардал	-	-	-	-
Халаалтын зардал	-	-	-	-
Сэлбэг хэрэгсэл	-	-	-	-
Сургалтын зардал	-	-	-	-
Албан томилолт	3,826,100.00	2,826,100.00	-1,000,000.00	73.86%
Үйл ажиллагааны зардал	-	-	-	-
Үйл ажиллагааны бус зардал	-	-	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг	-	-	-	-
Орлогын татварын зардал	-	-	-	-
Цэвэр ашиг	-	-	-	-
Орлогын 1 төгрөгт ногдох зардал	-	-	-	-
Нийт авлага	-	-	-	-
Нийт өглөг	-	-	-	-
Хөрөнгө худалдан авалт	-	-	-	-

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.03.06	Аудитын нэр: 2018 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшинд хийсэн аудитын тайлан	Аудитын код: САГ-2019/46/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Мал эмнэлэгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ	Сая төгрөгөөр	

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Тайлант хугацаанд ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 46.3.2-т "байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулах", Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын хавсралт "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2-т "Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэт арга барилаар ажиллаж өндөр амжилт гаргасан, эсвэл гоц авьяастай ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоно" гэж заасныг, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, үнэлгээ хуваарилалт, эрх ба үүрэг гэх батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Ц.Гантөмөр Д.Байгалмаа
Авлага, өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс тус тус өссөн нь санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Ц.Гантөмөр Д.Байгалмаа

[illegible]